

СҮХБААТАР ДҮҮРГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН

2025 оны 06 дугаар сарын 10

Улаанбаатар хот

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /Хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
Стратегийн зорилго. Нийгмийн эрүүл мэнд, эмнэлгийн тусламж, үйлчилгээг хүн амын эрүүл мэндийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн чанартай, аюулгүй, үр дүнтэй үзүүлэх							
Стратеги төлөвлөгөөний зорилт 1. Иргэдийн эрүүл мэндэд нөлөөлөх хүчин зүйлийг тандах, эрүүл мэндийг дэмжих, өвнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, хянах арга хэмжээг эрчимжүүлэн нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг цогцоор үзүүлнэ. (МУХТЖТ-2.2.2, 2.2.8, МУХТЖҮЧ-2.2.1, НХТЖҮЧ-2.5, 2.6, 2.7, 2.9.1, 2.9.2, 2.11.1, НЗДҮАХ- 2.1, НХЖТ-2.1)							
1.1	Зорилтот бүлгийн эмэгтэйчүүдийн бүртгэл судалгааг шинэчилж, урьдчилан сэргийлэх үзлэг, жирэмслэхээс сэргийлэх арга хэрэгсэлд хамруулах		Урьдчилан сэргийлэх үзлэгийн хамрагдалт, эрүүлжүүлэлтийн хувь	75,5/72	80/80	Сүхбаатар дүүргийн нөхөн үржихүйн насны 35435 эмэгтэйчүүдийн судалгааг нарийвчлан гаргаж, 2025 оны эхний хагас жилийн байдлаар амбулаториор 9505 эмэгтэйд тусламж үйлчилгээ үзүүлсэн. Үүнээс 7199 эмэгтэйгийн 75.7%-ийг эмчлэн эрүүлжүүлсэн байна. Зорилтот бүлгийн 5301 эмэгтэйчүүдийн судалгааг урьдчилсан байдлаар гаргаж, 2025 оны эхний 5 сарын байдлаар 4340 эмэгтэйг урьдчилан сэргийлэх үзлэгт 81.8%-тай хамруулсан байна. Үзлэгээр 599 эмэгтэйд өвчлөл илэрсэн илэрсэнээс 102 тохиолдлыг лавлагаа шатлалын эмнэлэгт илгээж, 420 буюу 70.1%-ийг эмчлэн эрүүлжүүлсэн.	90

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /Хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтг элийн хувь
						ЭМС-ын 2024 оны А/11 дугаар тушаал, НЭМГ-ын даргын 2025 оны А/94 дугаар тушаалаар батагдсан “Хариуцлагатай сонголт аяны хүрээнд ӨЭМТ-үүдэд Эх барих, эмэгтэйчүүдийн эмч нарын үзлэгийн хуваарь гарган ажиллуулахаар шаардлагатай багаж, хэрэгслийн бэлэн байдлыг хангасан.	
			Жирэмслэхээс сэргийлэх Арга хэрэгсэлд хамрагдсан хувь	57.7	60	Зорилтот бүлгийн 5301 эмэгтэйгээс 2025 оны эхний хагас жилийн байдлаар 2949 эмэгтэйг жирэмслэхээс сэргийлэх арга хэрэгсэлд хамруулсан. /55.6%/-тай байна.	90
1.2	Нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтэн, ажилтнуудыг мэргэжлийн чиглэлээр сургалтад хамруулж, чадавхижуулах		Сургалтад хамрагдсан ажилтны тоо	-	5	Эх хүүхдийн хоол тэжээл, “Халдварт бус өвчнийг хянах, сэргийлэх, эрсдэлт хүчин зүйлийг бууруулахад мэргэжил аргазүйн дэмжлэг үзүүлэх”, Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, Хүний папиломма вирусын халдвар сэдвүүдийн хүрээнд 4 удаагийн сургалтад 21 нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтэн хамрагдсан.	90
1.3	Нийгмийн эрүүл мэндийн тэмдэглэлт өдрүүдийн хүрээнд хүн амд эрүүл		Тэмдэглэн өнгөрүүлсэн өдрийн тоо	6	12	Осол гэмтлээс сэргийлэх “Crash landing on carbon dioxide”, “Хорт зуршлаас ангид байя” сарын аян,	90

д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /Хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
	мэндийн боловсрол олгох арга хэмжээг хэрэгжүүлэх		Хамрагдсан хүний тоо	296	500	“Маскаа зүүцгээе” аян, Охид эмэгтэйчүүдийн эрүүл мэнд, Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийг хамгаалах өдөр, Сүрьеэтэй тэмцэх дэлхийн өдөр, Шүдээ зөв угаая аян Өсвөр үеийнхнийг сонсьё, ойлгоё”, - “Хүний папиллома вирусийн эсрэг нөхөн дархлаажуулалтыг эрчимжүүлэх” аян, Агаар орчны бохирдлоос хүн амын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх зөвлөгөө, мэдээллийг олон нийтэд түгээх аян зэрэг нийт 10 удаагийн тэмдэглэлт өдрийг тэмдэглэн өнөгрүүлж, дараах арга хэмжээг хэрэгжүүлсэн. Үүнд: - Урьдчилан сэргийлэх үзлэгт 223 хүн хамруулж, сүрьеэгийн 1 тохиолдол илрүүлж, эмчилгээнд хамруулсан. - Сургалт 92 удаагийн сургалтад 5414 хүн хамруулсан. - Мэдээлэл , зөвлөмж 666 удаа, 133619 хүнд түгээсэн. - Видео зөвлөмж 15 удаа - Шинээр бэлтгэсэн үе тэнгийн сургагч багш-143	

д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /Хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
1.4	Зонхилон тохиолдох халдварт өвчин, шинэ болон сэргэж буй халдварт өвчний чиглэлээр олон нийтэд чиглэсэн, мэдээлэл, сурталчилгааг эрчимжүүлэх		Түгээсэн зөвлөмжийн тоо	48	60	Зонхилон тохиолдох томуу томуу төст өвчин, хүний папиллома вирус, улаанбурхан өвчний талаар нийт 40 удаагийн зөвлөмжийг олон нийтийн цахим сүлжээнд байршуулж, 30323 иргэнд мэдээлэл хүргэсэн.	100
			Цахим хуудсаар мэдээлэл авсан хүний тоо	14000	25000		
1.5	Сүрьеэгийн хавьтал илрүүлэлтийг нэмэгдүүлэн шинэ тохиолдол бүрийг эмчилгээнд хамруулж, эмчилгээний чанарыг дээшлүүлэх		Хавьтлын илрүүлэлтийн хувь	70	75-80	СБД-т 2025 оны 5 сарын байдлаар шинэ болон давтан сүрьеэгийн 57 тохиолдол эмчилгээнд хамрагдсан. Үүнээс шинээр 29 тохиолдол шинээр илэрсэн. Үүнээс сүрьеэгийн 133 хавьтлыг тодорхойлсоноос 77 буюу 57,8%-ийг хавьтлын үзлэгт хамруулсан. Үзлэгээр сүрьеэгийн тохиолдол илрээгүй, сүрьеэгийн урьдчилан сэргийлэх эмчилгээнд 15 хүүхэд хамруулсан.	30
			Эмчилгээний хамрагдалтын хувь	100	100	Онош батлагдсан 57 тохиолдлыг 100% буюу эмчилгээнд бүрэн хамруулсан.	
			Эмчилгээний амжилтын хувь	80.2	90	Эмчилгээний амжилтын хувь тооцох хугацаа болоогүй.	

д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /Хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
1.6	Сүрьеэгийн хавьтлын 0–16 насны хүүхдийг хавьтлын үзлэгийн туберкулины сорил, цусанд интерферон гамма /IGRA/ илрүүлэг шинжилгээнд бүрэн хамруулж, эерэг тохиолдол бүрийг сүрьеэгийн урьдчилан сэргийлэх эмчилгээнд бүрэн хамруулах		Эмчилгээнд хамрагдалтын хувь	100	100	Сүрьеэгийн батлагдсан тохиолдлын 133 хавьтлаас 0-16 насны 53 хүүхдийг туберкулины сорил-д, 60 хүүхдийг цусанд интерферон гамма /IGRA/ шинжилгээнд хамруулсан. Үүнээс 18 хүүхэд туберкулины сорил болон IGRA-д эерэг илэрч сүрьеэгийн урьдчилан сэргийлэх эмчилгээнд 15 хүүхдийг 3 сарын /3HP/ горимоор хамруулсан. 3 хүүхдийн асран хамгаалагч эмчилгээнээс татгалзсан.	70
1.7	БЗДХ-ын шинэ тохиолдол бүрийг эмчилгээнд хамруулж, эмчилгээний чанарыг дээшлүүлэх		Эмчилгээний амжилтын хувь	80.2	90	Эхний 5 сарын байдлаар зонхилон тохиолдох бэлгийн замаар дамжих халдварын нийт 107 тохиолдол шинээр бүртгэгдсэнээс тэмбүүгийн 56, заг хүйтэний 48, трихомониазын 3 тохиолдол илрүүлсэн. Өмнөх оны мөн үеэс тэмбүү 1,9 заг хүйтэн 2.6, трихомониаз 0,2 промилиор өссөн байна. Бүртгэгдсэн 107 тохиолдлын 90 буюу 84,1%-ийг эмчилгээнд хамруулсан. Эмчилгээний амжилт 84,7 хувьтай байна.	70

д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /Хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
1.8	Зорилтот бүлгийн хүн амын дунд БЗДХ-ын идэвхтэй хэлбэрийн эрт илрүүлэг үзлэг зохион байгуулж, илэрсэн тохиолдлыг эмчилгээнд бүрэн хамруулах		Илэрсэн өвчлөлийн тохиолдлыг эмчилгээнд хамруулсан хувь	100	100	БЗДХ-ын идэвхтэй хэлбэрийн эрт илрүүлэгийн үзлэгт нийт 908 хүн хамруулж, тэмбүүгийн 4 тохиолдол илрүүлсэн. Эмчилгээнд хамрагдалт 100% Хавьтлын эмчилгээнд хамрагдалт 100%.	100
1.9	Дархлаажуулалт бүхий халдварт өвчний тандалтыг эрчимжүүлж дархлаажуулалтын нэгжүүдийн хэвийн үйл ажиллагааг хангах замаар товлот дархлаажуулалтын хамрагдалтыг нэмэгдүүлэх		Товлолт дархлаажуулалтын хувь	96	97	Эхний 5 сарын байдлаар товллын дархлаажуулалтад хамрагдвал зохих 9728 хүүхдээс 9564 хүүхэд хамруулсан буюу 98,3% байгаа нь өмнөх оны мөн үеэс 0.7 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Дархлаажуулалтын хамралтыг эрчимжүүлэхээр СБД-ийн Засаг даргын захирамж 1, ЭМТ-ийн даргын албан даалгавар 2, Зөвлөмж 2 удаа гаргаж, дүүргийн Боловсролын хэлтэс, Хороодын ЗДАА, ӨЭМТ-үүдэд хүргүүлсэн.	100
1.10	Тархвар судлалын заалтаар хийгддэг өвчний эсрэг дархлаажуулалтыг нэмэгдүүлэх замаар халдварт өвчний тохиолдлыг бууруулах	-	Товлолт дархлаажуулалтын хувь	95	96	Сүхбаатар дүүргийн Эрүүл мэндийн төв, Өрхийн эрүүл мэндийн төв нь нийт 245 ажилтантай. Үүнээс улаанбурхан өвчний эсрэг дархлаажуулалтад хамрагдвал зохих 181 эмч, эмнэлгийн ажилчдаас 147 эмч, эмнэлгийн ажилчдыг буюу 81,2 хувийг	90

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /Хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
						хамруулсан. Мөн Арьсны өвчин судлалын үндэсний төвийн 31, Сүхбаатар Нэгдсэн эмнэлгийн 20 ажилчид хамрагдсан. Мөн улаанбурханы батлагдсан тохиолдлын хавьтал болох 158 иргэнийг дархлаажуулалтад хамруулсан. Улаанбурхан, гахай хавдар, улаануудын дархлаажуулалтад 4 сарын байдлаар 9 сартай 501, 2 настай 620, 2-5 насны 289, 6-10 насны 31, 11-15 насны 6 буюу нийт 1447 хүүхдийг хамруулсан.	
1.11	Дүүргийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудтай хамтын ажиллагааны хүрээнд 6 настай хүүхдийн амны хөндийн урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулах, илэрсэн өвчлөлийг эмчлэн эрүүлжүүлэх	-	Эмчилгээнд хамрагдсан хүүхдийн хувь	30	80	Шүдний эмгэг илрүүлэх үзлэгийг 2025 оны 01 сарын 30-аас 04 сарын 30-ны өдрийн байдлаар 11 өрхийн эрүүл мэндийн төв, 17 хувийн хэвшлийн шүдний эмнэлэгтэй хамтран зохион байгуулж 1-р шатны үзлэгт 3661 хүүхэд хамрагдсан. 2-р шатны сийлэнт түрхлэг түрхүүлсэн хүүхдийн тоо 1737, 3-р шат буюу эмчилгээ хийлгэсэн хүүхдийн тоо 571 хамрагдсан байна.	30

д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /Хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
1.12	Хүн амын нас хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг, үзлэг, оношилгоо, шинжилгээг Эрүүл мэндийн төв, Сэлбэ эмнэлгийн амбулаторийг түшиглэн зохион байгуулж ажиллах	-	Үзлэг, шинжилгээ, оношилгооны хамрагдалтын хувь	60.1	70.1	Хүн амын нас хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг оношилгоо, шинжилгээнд 141537 иргэнээс 85748 буюу 60.6%-ийг эрт илрүүлгийн багц үзлэгт хамруулж, хавдрын сэжигтэй 519 тохиолдлыг илрүүлж, дараагийн шатлалын эмнэлэгт илгээсэн. Хавдрын сэжигтэй тохиолдлын 31-45 насны иргэд 45,7%-ийг 46-60 насны иргэд 28,7%-ийг, 61-ээс дээш насны- 25,5%- ийг тус тус эзэлж байна.	70
1.13	Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн байр, хүний нөөц, хүн амын мэдээлэлд дүн шинжилгээ хийж амны хөндийн тусламж үйлчилгээ үзүүлэх эмч, сувилагчийг үндсэн болон гэрээт орон тоогоор ажиллуулах		Шүдний тусламж үйлчилгээг нэвтрүүлсэн ӨЭМТ-ийн тоо	0	1	Амны хөндийн тусламж үйлчилгээ үзүүлэх боломжтой өрхийн эрүүл мэндийн төвийн байр, тоног төхөөрөмжийн судалгааг гаргаж НЭМГ-т хүргүүлсэн. Эхний хагас жилд 17 дугаар хорооны Увидаст од ӨЭМТ нь шүдний кабинет, тоног төхөөрөмжөөр хангагдсан, мэргэшсэн хүний нөөц байхгүй байна.	30
1.14	Нийгмийн эрүүл мэндийн төв байгуулахад шаардлагатай хүний	-	Үйл ажиллагааны	-	30	Нийгмийн эрүүл мэндийн төв байгуулахад шаардлагатай хүний нөөц, тоног төхөөрөмж, барилга	100

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /Хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
	нөөц, тоног төхөөрөмж, барилга байгууламж, төсвийн тооцооллыг гарган, холбогдох дээд шатны байгууллагуудад хүсэлт хүргүүлж, бэлтгэл ажлыг хангах		хэрэгжилтийн хувь			байгууламжийн судалгааг гаргаж НЭМГ-т хүргүүлсэн.	
Стратеги төлөвлөгөөний зорилт 2. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чадавхыг бэхжүүлэн чанар, үр дүнг тасралтгүй сайжруулж, хүртээмжийг нэмэгдүүлнэ (АХ-2.2, ЗГҮАХ-2.3.2, ХТЖҮЧ-3.1.2, НХТЖҮЧ-2.8, 2.9, 2.10, НЗДҮАХ-2.1.3, 2.1.6, ДЗДҮАХ- 2.1.6, ДХЖТ-2.1.6)							
2.1	“Сэлбэ” эмнэлгийг түшиглэн насанд хүрэгчдийн хүлээн авах, яаралтай тусламж, эрчимт эмчилгээ, өдрийн болон хэвтэн эмчлүүлэх хорт хавдрын системийн хими эмчилгээ, дотор, мэдрэлийн хэвтүүлэн эмчлэх тасгийн тусламж, үйлчилгээг үе шаттай эхлүүлж, эмнэлгийн бүсэд оршин суух хүн амын тусламж, үйлчилгээний хүртээмжийг сайжруулах	-	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	30	70	- НЭМГ-ын даргын 2024 оны А/45 дугаар тушаалаар батлагдсан ЭМДҮЗ-ийн 04 дүгээр тогтоол, 200 орны хуваарийг өвчлөлийн бүтэцтэй уялдуулан шинэчлэн баталж, нэмэлтээр хавдрын 30 орны тоог НЭМГ-т хүсэлт хүргүүлэн 2025 оны А/150 дугаар тушаалаар батлуулсан. - Сэлбэ эмнэлэгт 5 чиглэлийн тусламж үйлчилгээг нэвтрүүлэх, өргөжүүлэх төлөвлөгөө гарган хэрэгжүүлж байна. - Төлөвлөгөөний дагуу 2025 оны эхний улиралд 2 жилээр магадлан итгэмжлүүлсэн. 2025 оны 2 дугаар улиралд хавдрын хими, хөнгөвчлөхийн 30 ортой тасаг,	30

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /Хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
						насанд хүрэгчдийн яаралтай тусламж, эрчимт эмчилгээний 4 ортой тасгийг нээхээр төлөвлөснөөс бэлтгэл ажил 70%-ийн хэрэгжилттэй байна. Бэлтгэл ажлын хүрээнд: - Төрөлжсөн мэргэшлийн 3 эмч, 1 сувилагч шинээр авсан. - УНТЭ-т 2 сувилагч, ХСҮТ-д 3 сувилагчийг дагалдуулан сургасан. - Эмнэлгийн 1-р давхарт Эрчимт эмчилгээ яаралтай тусламжийн тасаг, 3-р давхарт хавдын хими, хөнгөвчлөхийн тасаг нээх урсгал зохион байгуулалт хийсэн. - БГДЭМТ-ийн "ХАВДРЫН ТӨВ" н үйл ажиллагаа зохион байгуулалттай 9 ажилтан танилцаж, сайн туршлага судалсан. СБДЗДТГ-т шаардлагатай тоног төхөөрөмжийн судалгааг хүргүүлж, 2025 оны төсөвт 2,7 тэрбум төгрөг шийдвэрлүүлсэн. Тендер зарлагдсан.	

д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /Хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
2.2	Чихрийн шижингийн нэг цэгийн төв байгуулах		Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	-	100	СБДЭМТ-д Чихрийн шижингийн нэг цэгийн төв байгуулах ерөнхий төлөвлөгөөг 5 заалттай гаргасан. Үүний хүрээнд: - СБД-ийн хэмжээнд нийт бүртгэлтэй 3044 чихрийн шижин өвчтэй үйлчлүүлэгчийн судалгааг нарийвчлан гаргасан. Үүнээс чшхш1 оноштой 23, чшхш2 оноштой 3021 байгаагаас одоогийн байдлаар амбулаторийн хяналтанд 3000 иргэн тогтмол хянагдаж байна. - Чихрийн шижинтэй нүдний хүндрэлтэй-73, бөөрний хүндрэлтэй-70 хүн, тодорхой бусад хүндрэлтэй том судасны хүндрэлтэй-2817 үйлчлүүлэгчийн судалгааг гаргаж, эмчилгээний үр дүнг хянаж ажиллаж байна. - СБЭМТ-ийн 100 айл дахь амбулаторийн 4-р давхарт Чихрийн шижингийн төв байгуулахаар төлөвлөлт хийж, засвар тохижилт явагдаж байна.	30

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /Хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
						- ХУДНЭ-ийн Чихрийн шижингийн нэг цэгийн үйл ажиллагаатай танилцсан.	
2.3	Гемодиализийн тусламж, үйлчилгээг нэвтрүүлж, зорилтот бүлгийн иргэдийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх		Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	-	100	Сэлбэ эмнэлгийн 2 дугаар давхарт диалез эмчилгээний 10 сандал байршуулахаар зохион байгуулалт хийсэн. Үүнээс 2025 онд 5 Гемодиализын аппаратыг орон нутгийн төсвийн хөрөнгөөр шийдвэрлүүлэхээр 2025 оны төсөвт суулгаж, тендер зарлагдсан. Гемодиализийн тусламж, үйлчилгээг үзүүлэх 1 эмч, 1 техникчийг шинээр ажилд авч, УНТЭ-тэй санамж бичгийн дагуу туршлага судлуулсан.	30
2.4	Нүдний тусламж үйлчилгээнд компьютер томографын /ОСТ/ оношилгоог нэвтрүүлж, нүдний эмгэгийн илрүүлэлт, хяналтын чанарыг сайжруулах		Оношилгоонд хамрагдсан хүний тоо	-	50	Нүдний тусламж үйлчилгээ 2025 оны эхний 5 сарын байдлаар нийт 1861 үйлчлүүлэгч үзүүлснээс нүдний компьютер томограф хийлгэх шаардлагатай /ОСТ/- нийт 23 хүнийг оношилгоонд хамруулсан. Үүнээс шар толбоны хаван-1, хөгшрөлийн шалтгаант шар толбоны сөнөрөл -10 илэрсэн.	30

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /Хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
2.5	Өндөр өртөгт болон нэн шаардлагатай оношилгоо, шинжилгээний нэр төрлийг нэмэгдүүлж, тусламж үйлчилгээг өргөжүүлэх		Шинээр нэмэгдүүлсэн оношилгоо, шинжилгээний нэр төрлийн тоо	3	5	Шинээр 2 төрлийн өндөр өртөгт шинжилгээ, оношилгоог нэвтрүүлэхээр төлөвлөсөн. Үүнд: - СБДЗДТГ-аас СБДХАА/20240102017 дугаартай гэрээний дагуу 3 тэрбум төгрөгийн өртөг бүхий германы Siemens Somatom go.all загварын 128 зүслэгтэй компьютер томографын аппаратыг Сэлбэ нэгдсэн эмнэлгийн дүрс оношилгооны тасагт суурилуулсан. УНТЭ-т 1 их эмч 1 техникчийг сургалтад хамруулж бэлтгэж байна. - СБДЗДТГ-аас 540 сая төгрөгийн үнэ бүхий мэс заслын дурангийн иж бүрдэл шинээр авч, суурилуулахаар 2025 оны төсөвт тусгаж, шийдвэрлэсэн. IMS engineering ХХК тенперт шалгарч, гэрээ байгуулах шатанд байна.	30

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /Хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
2.6	Хяналтгүй болон гэрийн төрөлт, амьгүй төрөлт, өсвөр насны хүүхдийн төрөлт, үр хөндөлтөд жирэмсний хяналтад ороогүй зэрэг шалтгаанд дүн шинжилгээ хийж, нөлөөлж буй хүчин зүйлийг судлан түүний мөрөөр давтан гарахаас сэргийлэх ажлыг зохион байгуулах		Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	90	100	Үйл ажиллагааны 3 төлөвлөгөө гарган хэрэгжүүлж байна. Үүнд: - СБДЗДТГ-тай хамтран Эх, хүүхдийн орон тооны бус салбар зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөө 24 арга хэмжээтэй, хэрэгжилт-70% - Эх, хүүхдийн тусламж, үйлчилгээг сайжруулах 6 зорилт, 26 арга хэмжээтэй төлөвлөгөө гарган хэрэгжүүлж байна. хэрэгжилт-70%. - НЭМГ-ын А/94 “Хариуцлагатай сонголт” аяныг хэрэгжүүлэх 5 зорилтын хүрээнд 13 ажил төлөвлөн хэрэгжүүлж байна. Хэрэгжилт-70%. Үндсэн үзүүлэлт: Эхний 5 сарын байдлаар нийт 1520 жирэмсэн хяналтад байна. Үүнээс: нийт төрсөн эх 635 байна. Амьд төрөлт 642 байгаа нь өмөнө оны мөн үеэс 35 тохиолдлоор өссөн байна. Амьгүй төрөлт- 4 тохиолдол буюу 6,2 промель байгаа нь өмнөх оны мөн үеэс 6,9 промилоор буурсан. Хяналтгүй төрөлт- 7 тохиолдол буюу өмнө оны мөн үеэс 3 тохиолдол буюу 1,1%-иар өссөн.	70
			Амьгүй төрөлтийн тохиолдлын тоо	16	15		
			Гэрийн төрөлтийн тохиолдлын тоо	4	3		
			Хяналтгүй төрөлтийн тохиолдлын тоо	8	7		
			Өсвөр насны хүүхдийн төрөлтийн тоо	41	35		

д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /Хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
						Өсвөр насны хүүхдийн төрөлт-21 тохиолдол бүртгэгдсэн байна.	
2.7	Эмнэлгийн бус нөхцөлд эндсэн хүүхдийн эндэгдлийн шалтгаанд дүн шинжилгээ хийж, нөлөөлж буй хүчин зүйлийг судлан түүний мөрөөр давтан гарахаас сэргийлэх ажлыг зохион байгуулах		Хэлэлцсэн хурлын тоо	3	4	Эмнэлгийн бус нөхцөлд эндсэн хүүхдийн тохиолдол 2025 он гарснаас хойш бүртгэгдээгүй.	70
			Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	70	90		
			Эмнэлгийн бус нөхцөлд эндсэн хүүхдийн тоо	2	1		
			0-5 насны хүүхдийн хяналтгүй нас баралтын тоо	2	0		
2.8	“Эхээс урагт дамжих гурвалсан халдвар”-ыг бууруулах, ургийн гажиг		Ургийн гажиг илрүүлэх 4D ЭХО аппаратын тоо	1	2	“Эхээс урагт дамжих гурвалсан халдвар”-ыг бууруулах, ургийн гажиг эрт илрүүлэх аппаратны тоо-1 СБД-ийн ЗДТГ-т ургийн гажиг эрт илрүүлэхэд шаардлагатай 1 аппаратны техник үзүүлэлтийг гаргаж, хүргүүлсэн, 2025 оны төсөвт тусгуулсан. Тендер зарлагдсан байна.	30

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /Хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
	эрт илрүүлэх боломжийг бүрдүүлж, жирэмсний эрт хяналтыг нэмэгдүүлэх		Жирэмсний эхний 3 сард хяналтад орсон эмэгтэйчүүдийн хувь	92.3	93	Эхний 5 сарын байдлаар 1520 жирэмсэн хяналтад байна. Жирэмсний эхний 3 сарын эрт хяналт /91.7%/	90
			PCR шинжилгээний үйл ажиллагаа тогтмолжсон лабораторийн тоо	-	1	PCR шинжилгээний үйл ажиллагаа тогтмолжуулахад шаардлагатай судалгааг гаргаж, бэлтгэл ажлыг хангаж байна. Үүнд: - Тоног төхөөрөмж бүрэн хангагдсан. 2025 оны эхний улиралд боловсруулалт хийсэн сорьцноос нуклейн хүчлийг "Healgen" нуклейн хүчил ялгах автомат системээр Viral Nucleic Acid Extraction Kit (Magnetic beads) ашиглан, БхПГУ-ыг BIO-RAD CFX96 DxORM олшруулагч машинаар NeoPlex™ STI-7 Detection Kit ашиглан эмэгтэй 128, эрэгтэй 12 хүнд шинжилгээ хийсэн. Эрэгтэй хүнээс шээс, эмэгтэй хүнээс умайн хүзүүний арчдас авч шинжилсэн. Шинжилгээгээр нийт сорьцын	70

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /Хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
						63.5%-д (89) бэлгийн замаар дамжих халдвар илэрсэн. - 2025 оны 2 дугаар улиралд хүний нөөцийн хомсдолтой холбоотой хийгдээгүй.	
			Илрүүлсэн ургийн гажгийн тоо	23	20	Ургийн хэт авиан шинжилгээнд нийт 1258 жирэмсэн хамрагдсан үүнээс ургийн гажиг илрээгүй байна.	100
2.9	Хүүхдийн өвчлөлийн цогц менежментийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах		ХӨЦМ-ийн хэрэгжилтийн хувь	80	90	Хүүхдийн өвчлөлийн цогц менежментийн хэрэгжилтэд нийт 20 хорооны 16 ӨЭМТ-ийн тусламж үйлчилгээнд хяналт хийсэн. Хяналтаар илэрсэн зөрчил бүрийг илрүүлэн зохих эмч эмнэлгийн ажилчдад ажлын байран дээрх сургалтыг хийсэн. 16 ӨЭМТ-үүд нийт амбулаториор үзүүлсэн 0-5 насны хүүхэд 4873 байгаагаас ХӨЦМ-өөр үнэлсэн хүүхдийн тоо-3996. Үүнээс суурь эмгэг илрүүлсэн хүүхдийн тоо-234 байна. ХӨЦМ-ийн хэрэгжилтийн хувь-82. 2025 оны хагас жилийн Хүүхдийн өвчлөлийн цогц менежментийн сургалтад хамрагдах өрхийн эмч нарын судалгааг авч нэгтгэсэн.	90

Д/Д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /Хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
						Сургалтыг 6 дугаар сарын 12-13-ны өдрүүдэд зохион байгуулна.	
2.10	Хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх 9, 18, 36 сартай хүүхдийн үзлэг зохион байгуулж, хоцрогдолтой хүүхэдтэй ар гэр, асран хамгаалагч нарын хүүхдээ хөгжүүлэх, дэмжих, мэдлэг ур чадвар дадлыг нэмэгдүүлэх чиглэлээр арга хэмжээ хэрэгжүүлэх		Хамрагдалтын хувь	65	80	ЭХЭМД болон 3 сайдын хамтарсан тушаалын дагуу үзлэгийн хуудсаар цогц үзлэгт хамруулдаг. А/220, А/475, А/812 дугаар хамтарсан тушаалыг баримтлан 9, 18, 36 сартай хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийн цогц үзлэгт нийт 2025 онд нийт 5004 хүүхдийг хамруулахаас эхний 4 сарын байдлаар 612 буюу 12%-ийг илрүүлэг үзлэг хамруулсан. Үзлэгээр 14 хүүхдэд хөгжлийн үнэлгээнд өөрчлөлт илэрсэн тул дараагийн шатлалд онош тодруулахаар илгээснээс 3 хүүхэд онош батлагдан байнгын асаргаа тогтоолгосон.	30
			Зөвлөгөө, сургалтад хамрагдсан ар гэр, асран хамгаалагчийн тоо	-	44	СБЭМТ болон СБД-ийн ӨЭМТ-н фэйж хуудсаар эцэг эх асран хамгаалагч нарт үзлэгт хамруулах, түүнээс илэрсэн бэрхшээлийг эрт илрүүлэн холбогдох арга хэмжээг авах талаар 792 хүүхдийн эцэг эх асран хамгаалагч нарт зөвлөгөө зөвлөмжийг өгсөн.	100

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /Хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
						2025 оны эхний улиралд шинээр оношлогдсон 3 хүүхдэд байнгын асаргаа тогтоож, ар гэр, асран хамгаалагчид зөвлөгөө өгсөн.	
2.11	“Сайн дурын авлагагүй донорын эгнээг өргөжүүлж, аюулгүй цус, цусан бүтээгдэхүүний бэлдмэлийн хангамжийг нэмэгдүүлб” өдөрлөг зохион байгуулах		Шинээр нэмэгдсэн авлагагүй донорын тоо	2	4	Цус сэлбэлт судлалын үндэсний төвтэй хамтран “Сайн дурын авлагагүй донорын эгнээг өргөжүүлж, аюулгүй цус, цусан бүтээгдэхүүний бэлдмэлийн хангамжийг нэмэгдүүлб” өдөрлөгийг 05 сарын 15-ны өдөр зохион байгуулж 29 эмч, эмнэлгийн мэргэжилтэн сайн дураар хамрагдаж 87 хүний амийг аврахад хувь нэмрээ оруулсан. Шинээр нэмэгдсэн авлагагүй донорын тоо-3	90
2.12	Цэргийн насны залуучуудын эрүүл мэндийн үзлэгийн богино болон урт хугацааны эрүүлжилтийн хувь нэмэгдүүлэх		1,2-р ээлжний богино хугацааны эрүүлжилтийн хувь	15	20	2025 оны 1- р ээлжийн цэрэг татлагад 2025 оны 05 дугаар сарын 02-04-ны өдрүүдэд 32 хүний бүрэлдэхүүнтэй ажилласан. Цэрэг татлагад нийт 544 залуус хамрагдсанаас 242/44.5%/ залуус өвчний улмаас чөлөөлөгдөж , 18 /7.3% / залуус 07 тоот тушаалаар чөлөөлөгдсөн. 2024 оны 2-р ээлжийн цэрэг татлагаас 80 залууг хяналтад авч, 15%-ийг	30

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /Хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
						эрүүлжүүлэн НЭМГ-т тайланг хүргүүлсэн.	
			1,2-р ээлжний урт хугацааны эрүүлжилтийн хувь	-	3	Өвчний улмаас чөлөөлөгдсөн 242 залуусын 53 буюу 21.9% нь дотор, 20 буюу 8.3% нь мэс засал, 21 буюу 8.7% нь нүд, 29 буюу 12% нь сэтгэц, 24 буюу 9.9% нь чих, хамар хоолой, 25 буюу 10.3% нь гэмтэл, 28 буюу 11.6% нь мэдрэл, 5 буюу 2.1% нь шүд, 7 буюу 2.9% нь сүрьеэ, 19 буюу 7.8% нь жингийн илүүдэл ба бууралт, 6 буюу 2,8% нь арьс харшил, 2 буюу 0.8% нь БЗДХ өвчтэй оношлогдсон. Дээрх хасагдсан цэргийн насны залуусыг төрөлжсөн мэргэшлийн эмч нар эмчлэн эрүүлжүүлэхээр хяналтад авсан.	
2.13	Ахмад настны үзлэгийг зохион байгуулж, эмчлэн эрүүлжүүлэх		Эрсдэлт бүлгийн ахмад настанг үзлэгт хамруулсан тоо	-	605	Эрүүл мэндийн сайдын “Үзлэг зохион байгуулах тухай” 2025 оны А/28 дугаар тушаалын дагуу “Ахмад настны үзлэг”-ийг 2025 оны 02 дугаар сарын 01-нээс 03 дугаар сарын 31-ний хооронд Сэлбэ эмнэлэг болон Сүхбаатар дүүргийн Нэгдсэн эмнэлэгт нийт 10 удаа зохион байгуулсан.	100

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /Хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
						Үзлэгээр 14 төрлийн оношилгоо, шинжилгээ, 10 төрлийн төрөлжсөн мэргэжлийн эмчийн үзлэг, зөвлөгөө хийж, нийт 1012 ахмад настан хамрагдаж, давхардсан тоогоор 6208 удаагийн эмнэлгийн тусламж, үйлчилгээ авсан. Үүнээс Сэлбэ нэгдсэн эмнэлэг 782 ахмад настанд тусламж, үйлчилгээг үзүүлсэн.	
			Үүнээс эмчилгээнд хамрагдсан ахмад настны хувь	-	25%	Ахмад настны үзлэгт хамрагдсан 782 иргэнээс 310 иргэнийг хяналтад авч үүнээс лавлагаа шатлалын эмнэлэгт шинжилгээ, оношилгоонд 187 иргэнийг илгээсэн. Лавлагаа шатлалд илгээгдсэн 187 иргэнээс 41 иргэн буюу 13.2% нь өдрийн эмчилгээнд хамруулсан.	30
2.14	Гэр оронгүй тэнэмэл амьдралтай, эмзэг бүлгийн бүлгийн, архины хамааралтай хүн амд үзүүлэх тусламж, үйлчилгээний тасралтгүй байдлыг хангаж, хүртээмжийг нэмэгдүүлэх		Тусламж, үйлчилгээ авсан хүний тоо	120	120	Эрүүл мэндийн сайдын 2020 оны “Журам батлах тухай А/59 дүгээр тушаалын дагуу Гэр оронгүй тэнэмэл амьдралтай, эмзэг бүлгийн бүлгийн, архины хамааралтай 68 иргэнд СБД Цагдаагийн I, II хэлтэстэй хамтран 2025 оны 01 дүгээр сарын 21-нээс 2025 оны 04 дугаар сарын 30 -ны хооронд нийт 4 удаагийн үзлэг зохион байгуулж	30

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /Хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
						8 төрлийн оношилгоо, шинжилгээ, 10 төрлийн нарийн мэргэшлийн эмчийн тусламж үйлчилгээг үзүүлсэн.	
Стратеги төлөвлөгөөний зорилт 3. Олон улсын Чанарын менежментийн тогтолцоо ISO 9001:2015 стандартыг баримтлан тусламж үйлчилгээний чанар, аюулгүй, байдлыг тасралтгүй сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлэх (АХ-2.2, ЗГҮАХ-2.3.2, ХТЖҮЧ-3.1.2)							
3.1	Олон улсын Чанарын менежментийн тогтолцоо ISO 9001:2015 стандартын явцын үнэлгээнд хамрагдана	8.3 СБЭМТ	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	-	100	Олон улсын Чанарын менежментийн тогтолцоо ISO 9001:2015 стандартын явцын үнэлгээний товыг 2025 оны 07 сарын 03-04-нд төлөвлөж, ЭМТ-ийн даргын 2025 оны 06 сарын 03-ний өдрийн А/70 дугаар тушаалаар ISO 9001:2015 Чанарын менежментийн тогтолцоо стандартын баталгаажуулалтын магадлах-1 үнэлгээнд бэлтгэх ажлын хэсгийг томилж, 6 дотоод аудиторыг шинээр бэлтгэхээр ажиллаж байна. Бэлтгэл ажлын төлөвлөгөөний хэрэгжилт-30%.	30
3.2	Эрүүл мэндийн мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын албыг орон тоогоор тогтвортой ажиллуулах		Чанарын албаны албан тушаалтны чанарын албанд ажилласан дундаж сар	13	24	Монгол Улсын Шадар сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2019 оны 116/А/565 дугаар тушаалын дагуу 4 орон тоогоор ажиллуулахаар эрүүл мэндийн төвийн даргын 2025 оны А/01 дүгээр тушаалд тусгасан. Эхний хагас жилийн байдлаар албаны дарга,	70

д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /Хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
						аюулгүй байдал, эрсдэл хариуцсан менежер, чанарын мэдээллийн асуудал хариуцсан менежер гэсэн бүрэлдэхүүнээр ажилласан. Чанарын менежерийн сул орон тоог зарлаж хүний нөөцийг бүрдүүлэхээр ажиллаж байна.	
3.3	Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг бууруулах, сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх чиглэлээр арга хэмжээг хэрэгжүүлэх		Өргөдөл, гомдлын тоо	319	300	СБДЭМТ, СБД-ийн ӨЭМТ-үүдэд 2025 оны 05 сарын 22-ны байдлаар иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас нийт 148 өргөдөл, гомдол, санал, хүсэлт, талархал ирүүлсэн. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 21-ээр буурсан үзүүлэлттэй байна. Агуулгаар нь авч үзвэл: 61,5% нь талархал, 37,2% нь гомдол, 2024 оны мөн үетэй харьцуулахад талархал 4,1%-иар өсөж, хүсэлт 2,3%-иар буурсан байна. Сэтгэл ханамжийн хувь: 1313.mn үйлчлүүлэгчийн эерэг сэтгэл ханамжийн хувь: 72,7%. Амбулаториор 140 үйлчлүүлэгч хамрагдсанаас үйлчлүүлэгчдийн эерэг сэтгэл ханамжийн хувь: 92,7 байна.	90
			Иргэдийн сэтгэл ханамжийн хувь	82	83		
			Иргэдээс ирсэн өргөдөл гомдол шийдвэрлэлтийн дундаж хоног	7	6		

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /Хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
						Хэвтэн эмчлүүлэгчдээс 50 эмчлүүлэгч хамрагдсанаас эерэг сэтгэл ханамжийн хувь: 90%, Сэргээн засах төвд хэвтэн эмчлүүлэгчийн эерэг сэтгэл ханамж: 24 эмчлүүлэгч хамрагдсанаас - 79,2% Өргөдөл гомдол шийдвэрлэлтийн дундаж хугацаа: 5 хоног 3 цаг байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 19 цагаар буурсан үзүүлэлттэй байна.	
3.4	Харьяа эмнэлгүүдийг магадлан итгэмжлүүлж, тусламж үйлчилгээний чанарын үзүүлэлтийг хангаж ажиллах	28.0 СБЭМТ	Магадлан итгэмжлэлд хамрагдсан эмнэлгийн тоо	2	2	2025 онд шинээр магадлан итгэмжлүүлсэн эмнэлэг-2: - ЭМС-ын 2019 оны А/503 дугаар тушаалын хүрээнд СБДЭМТ-ийн харьяа Сэлбэ эмнэлгийг 2025 оны 03 сарын 10-нд Магадлан итгэмжлүүлэх үнэлгээнд хамруулсан. ЭМС-ын 2025 оны 04 дгээр сарын 04-ны өдрийн А/113 дугаар тушаалаар 55/2025 батламжийн дугаартай, магадлан итгэмжлэлийг 2 жилээр авсан. 2025 оны 06 сарын 02-ны өдөр Сэлбэ эмнэлгийн Магадлан итгэмжлэлийн нийт 127 зөвлөмж ирсэний дагуу төлөвлөгөө гарган ажиллаж байна.	100

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /Хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
						- Сэргээн засах төвийг 2025 оны 03 сарын 31-нд магадлангийн үнэлгээнд хамруулсан. ЭМС-ын 2025 оны 04 сарын 18-ны өдрийн А/141 тушаалын дагуу Магадлан итгэмжлэлийг 1 жилээр авсан. 2025 оны 06 сарын 02-ны өдөр Сэргээн засах төвийн Магадлан итгэмжлэлийн нийт 28 зөвлөмж ирсэний дагуу төлөвлөгөө гарган ажиллаж байна.	
3.5	Лабораторийн үйл ажиллагаанд чанарын гадаад хяналт хийлгэж, шинжилгээний үр дүнгийн баталгаат байдлыг хангаж, ажиллах	-	Гадаад хяналт, Үнэлгээний дундаж хувь	85	90	Лабораторийн шинжилгээний чанарын гадаад үнэлгээнд нийт 6 шинжилгээ хамруулах шаардлагатайгаас 2025 оны 5 дугаар сарын 20 нд 5 шинжилгээ хамрагдсан. Үүнд: цусны дэлгэрэнгүй шинжилгээ- Интэрмед эмнэлэг, биохими- УГТЭ, цус бүлэгнэлтийн шинжилгээ- Монгол- Японы эмнэлэг, цусаар дамжих халдварын шинжилгээ (ДОХ, тэмбүү, гепатит В, С)- ХӨСҮТ, цусны булэг , резус фактор- ЦССҮТ, шээсний шинжилгээ- УНТЭ Гадаад үнэлгээний дүн гараагүй байна. Нян судлалын шинжилгээний гадаад хяналтын хугацаа болоогүй.	100

3.6	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах “Сайн туршлага- 2024” бүтээлийг хэрэгжүүлэн, “Сайн туршлага- 2025” арга хэмжээнд шинэ технологи, бүтээл бэлтгэн оролцох		Хэвшүүлэх бүтээлийн тоо, нэр	1	4 (ЭМТ-2, ӨЭМТ-2) Чихрийн шижингийн нэг цэг, Өсвөр үеийн кабинет ажиллуулах, Өрхийн эмч нарт зориулсан зайлшгүй шаардлагат ай удирдамж, эмнэлзүйн заавруудын эмхтгэл 1.2 р боть / ном ашиглуулж хэвших, Амьсгалын замын халдварт өвчнөөр	ЭМТ-д хэвшүүлэх сайн туршлага-2. 1. Чихрийн шижингийн нэг цэг СБДЭМТ -д Чихрийн шижингийн нэг цэгийн төв байгуулах ерөнхий төлөвлөгөөг 5 бүлэгтэй гарсан. ХУДНЭ-ийн Чихрийн шижингийн нэг цэгийн үйл ажиллагаатай ЭМТҮЧАБА-ны менежер Э.Содбаяр, Төв амбулаторийн эрхлэгч Т.Ундрах нар танилцсан. ӨЭМТ-үүдэд хэвшүүлэх сайн туршлага-2 2. ХУД-ийн Ж.Болормаа эмчийн гаргасан өрхийн эмч нарт зориулсан зайлшгүй шаардлагатай эмнэлзүйн удирдамж, заавруудын эмхэтгэлийг 1-20 дугаар хорооны 16 ӨЭМТ-өөс захиалга авч 1 дүгээр ботиос 25 ширхэг, 2 дугаар ботиос 26 ширхэг тус тус захиалсан. 3. НЭМГ-ын даргын батласан Сайн туршлага арга хэмжээний заавал хэвшүүлэх бүтээлийг танилцуулах өдөрлөгт ЭМТҮЧАБА-с оролцсон. “Сайн туршлага-2024” арга хэмжээнд оролцсон бүтээлийг танилцуулан дэлгэрүүлэх 2025	30
-----	---	--	------------------------------	---	---	---	----

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /Хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
					өвдсөн 0-16 насны хүүхдийн өдрийн эмчилгээнд хэрэгжүүлэх	оны үйл ажиллагааны хөтөлбөрийн дагуу НЭМГ-с 14 хоног тутам зохион байгуулж байгаа цахим сургалтанд ЭМТҮЧАБА болон харьяа ӨЭМТ-үүдийн Чанарын багийн гишүүд хамрагдаж байна. Шинээр бүтээлээр оролцох хугацаа болоогүй.	
			Оролцох бүтээлийн тоо	4	5		
			Оролцсон эрүүл мэндийн ажилтны тоо	12	20		
3.7	“Чанарыг эрхэмлэгч хамт олон” аян зохион байгуулах	3.0 СБЭМТ	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	-	100	Аяны удирдамж хөтөлбөрийг боловсруулан НЭМГ-с арга зүйн зөвлөмж авсан. Чанарын менежментийн тогтолцооны хэрэгжилтийн үнэлгээтэй холбогдуулан 2025 оны 07 сараас 10 сард зохион байгуулахаар төлөвлөсөн.	30
3.8	“Сувилагч тусгай мэргэжилтний хөгжил, ур чадварын түвшин тодорхойлох” журмыг шинээр батлан хэрэгжүүлэх		Батлагдсан журмын тоо	-	1	“Сувилагч тусгай мэргэжилтний хөгжил, ур чадварын түвшин тодорхойлох” журмыг 2025 оны 03 дугаар сарын 07 өдрийн А/28 дугаар тушаалаар батлуулан, хэрэгжүүлж байна. Тушаалын хэрэгжилтийг хангах зорилгоор нийт 67 сувилагч, тусгай мэргэжилтнүүдэд 2 удаагийн	100

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /Хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
						сургалтыг үе шаттайгаар зохион байгуулсан.	
3.9	Нотолгоонд суурилсан сувилахуйн тусламж, үйлчилгээг бие даан үзүүлэх "Сувилахуйн төв"-ийн үйл ажиллагааг эхлүүлэх		Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувиар	-	70	Сувилахуйн төвийн бүтэц, үйл ажиллагаа MNS 6755:2019 стандарт, Журам батлах тухай ЭМС-ын 2017 оны 381 дугаар тушаалын дагуу "Хайр халамж сувилахуйн төвийн үйл ажиллагааны журам"-ыг боловсруулан, хянуулсан. Байнгын болон богино хугацаанд асаргаа сувилгаа шаардлагатай зорилтот иргэдэд сувилахуйн дагнасан, мэргэшсэн тусламж үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай 61.4 сая төгрөгийн тоног төхөөрөмжийн саналаа төсөвт тусгасан. СБД-ийн 3-р хороонд шинээр ашиглалтад орох Салбар амбулаторит 12 ортой төвийн үйл ажиллагааг төлөвлөсөн. Барилгын ажил 90%-тай байна.	30
3.10	Сургалт эрхлэх зөвшөөрлийн дагуу Сувилахуйн албыг түшиглэн шинэ сувилагч, тусгай мэргэжилтнийг		Батлагдсан хөтөлбөрийн тоо	-	4	Багц цагийн сургалт зохион байгуулахаар ЭМЯ-ны дэргэдэх Сувилахуйн салбар зөвлөлөөр 4 хөтөлбөр батлуулан, ЭМХТ-д хүргүүлсэн.	30
			Бэлтгэсэн сургагч багшийн тоо	-	24		

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /Хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
	сургах хөтөлбөр батлуулж, хэрэгжүүлэх		Сургалтад хамрагдсан шинэ сувилагч, тусгай мэргэжилтний тоо	9	12	ЭМХТ-ийн сургагч багш бэлтгэх сургалтад 24 сувилагч, тусгай мэргэжилтэн хамруулан, бэлтгэсэн. ЭМТ-ийн даргын 2025 оны А/31 дүгээр “Шинэ сувилагч, тусгай мэргэжилтнийг дадлагажуулах журам” тушаал батлуулан хэрэгжүүлэн ажиллаж байна. 2025 онд шинээр ажилд орсон 2 сувилагчийг дадлагажуулах хөтөлбөрт хамруулан сургаж байна.	
3.12	“Би сувилагч болмоор байна” одорлог зохион байгуулах		Оролцсон ЕБС-ын тоо	1	3	Сувилахуй, эх барихын хүний нөөцийг нэмэгдүүлэх, сурталчлах нэр хүндийг өсгөх зорилгоор Ерөнхий боловсролын 4, 159-р сургуулийн 10-12-р ангийн 74 сурагчдад 2025 оны 05 дугаар сард “Мэргэжил сурталчлах” 2 удаагийн өдөрлөг зохион байгуулсан. Ерөнхий боловсролын 4, 159 дүгээр сургуулийн 11, 12 дугаар ангийн сурагчдын дунд “Миний мэдэх сувилагч” сэдвээр эссэ бичих уралдаан зохион байгуулж, 36 эссэ ирүүлснээс 3-ийг шалгаруулж, шагнаж урамшуулсан.	100
			Хамрагдсан хүүхдийн тоо	42	60		
3.13	Өрхийн эрүүл мэндийн төвүүдтэй гүйцэтгэлийн гэрээ байгуулж,		Гүйцэтгэлийн гэрээний дүн	93.2	93.5	Дүүргийн 16 Өрхийн эрүүл мэндийн төвтэй 2025 оны 03 дугаар сарын 26-нд 3 талт гэрээг байгуулсан.	30

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /Хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
	хэрэгжилтэд хяналт тавьж, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллах					Гэрээний хэрэгжилтийг хангах зорилгоор эхний 3 сарын байдлаар ӨЭМТ-ийн дарга нарын шуурхайг 8 удаа, хүүхдийн тусламж үйлчилгээ хариуцсан эмч нарын уулзалтыг 3 удаа, нөхөн үржихүйн тусламж үйлчилгээ хариуцсан эмч нарын уулзалтыг 5 удаа, нийгмийн эрүүл мэндийн ажилтны уулзалтыг 2 удаа, Дүүргийн Эх хүүхдийн салбар зөвлөлийн хурлыг 1 удаа, 0-5 насны хүүхдийн эрүүл мэндийн үзүүлэлтийг 1 удаа тус тус хэлэлцэж, мэргэжил арга зүйгээр ханган ажиллаж байна. Эхний хагас жилийн гэрээний биелэлтийг 2025 оны 6 дугаар сарын 20-25-ны өдрүүдэд дүгнэхээр төлөвлөсөн.	
3.14	Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн яаралтай тусламжийн бэлэн байдалд дэмжлэгт хяналт хийж, түүний мөрөөр арга зүйгээр хангаж ажиллах		Үнэлгээний дундаж хувь	45	50	Улаанбурхан өвчний хариу арга хэмжээ болон яаралтай тусламжийн бэлэн байдлын хүрээнд нийт 14 ӨЭМТ-д дэмжлэгт хяналт хийж, арга зүйн зөвлөгөө өглөө. Үүнд 1, 3, 4, 6, 7, 8, 9, 12, 13, 14, 15, 16, 17, 18 дугаар хорооны ӨЭМТ хамрагдсан. Мөн ӨЭМТ-ийн дарга нарын шуурхай хуралдааны үеэр дэмжлэгт хяналтын	90

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /Хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
						явцад нийтлэг илэрсэн сайжруулах шаардлагатай үйл ажиллагааг танилцуулж, холбогдох чиглэл, үүрэг даалгаврыг өгсөн. 2025 оны 04 дүгээр сарын 23, 30-ны өдрүүдэд Нийслэлийн Эрүүл мэндийн газрын Эмнэлгийн тусламжийн хэлтсийн даргаар баталсан ажлын хэсэгтэй хамтран 4, 7, 9, 10 дугаар хорооны ӨЭМТ-д дэмжлэгт хяналт хийсэн. Хяналт нь хүүхэд, нярай, яаралтай тусламж, хөнгөвчлөхийн сувилахуйн тусламж үйлчилгээ болон лабораторийн тусламж үйлчилгээг хамарсан бөгөөд тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг үнэлэх, сайжруулах арга зүйн зөвлөгөө өгсөн.	
3.15	Өрхийн эрүүл мэндийн төвүүдэд хэрэгжих МОНПЭН төслийн хэрэгжилтэд дэмжлэгт хяналт хийх		Үнэлгээнд хамрагдсан ӨЭМТ-ийн тоо	-	8	2025 оны 1 дүгээр сарын 28, 29, 30-ны өдрүүдэд 16 өрхийн эмнэлэг болон СБД эрүүл мэндийн төвийн 50 ажилтан ДЭМБ-ын МОНПЭН төслийн сургалтанд хамрагдсан. Эхний 5 сарын байдлаар Артерийн гипертензийн эрт илрүүлэг үзлэгт хамрагдвал зохих 91811 иргэнээс 42635 буюу 46,3%, чихрийн шижин өвчний эрт илрүүлэг үзлэгт	30

д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /Хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
						хамрагдвал зохих 62400 иргэний 38891 буюу 62,3% нь тус тус хамрагдсан. Эрт илрүүлэг үзлэгээр артерийн гипертензийн 118, чихрийн шижин 2-р хэв шинжийн 52 тохиолдол илрүүлэн хяналтад авсан. Төслийн хэрэгжилтэд 7 дугаар сард дэмжлэгт хяналт хийхээр төлөвлөсөн байгаа.	
Стратеги төлөвлөгөөний зорилт 4. Хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлж, эмнэлгийн ажилтнуудын нийгмийн баталгааг дээшлүүлэх, ёс зүйн зөрчил, авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ. (АХ-1.3.10, 2.2.21, ЗГҮАХ-2.3.4, МУХЖТ-3.1.5)							
4.1	Эмнэлгийн ажилтнуудын нийгмийн баталгааг хангах дэд хөтөлбөрийн дагуу арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх		Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	95	96	Эмнэлгийн ажилтнуудын нийгмийн баталгааг хангах дэд хөтөлбөрийн дагуу 2025 онд 26 арга хэмжээг төлөвлөн ажиллаж байна. 2025 оны эхний хагас жилийн биелэлт 70 хувь. Эмнэлгийн ажилтнуудын ерөнхий сэтгэл ханнамжийн судалгааг 2025 оны 06 дугаар сард багтаан авахаар төлөвлөж, бэлтгэл ажлыг хангаж байна.	70
			Эмнэлгийн ажилтнуудын ерөнхий сэтгэл ханнамжийн хувь	70	80		
4.2	Эмнэлгийн дунд хугацааны стратеги төлөвлөгөөг боловсруулан батлуулах		Шинэчлэн батлуулсан стратеги төлөвлөгөөний тоо	-	1	СБДЭМТ-ийн 2025-2028 оны дунд хугацааны стратеги төлөвлөгөөг боловсруулах 19 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсгийг ЭМТ-ийн даргын 2025 оны 05 дугаар сарын	30

д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /Хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
						26-н өдрийн А/62 тушаалаар томилж, төлөвлөгөөг баталсан. Стратегийг шинээр боловсруулах ажлын хүрээнд байгууллагын 2020-2024 оны дунд хугацааны стратеги төлөвлөгөөний төгсгөлийн хяналт үнэлгээг хийсэн. Хэрэгжилтийн дундаж 87 хувь буюу зорилт тус бүрээр төлөвлөсөн арга хэмжээний гүйцэтгэлийг үнэлэхэд бүрэн хэрэгжсэн арга хэмжээ 50, хэрэгжих шатанд үнэлэгдсэн 3, хэрэгжээгүй 7 арга хэмжээ байна. Стратегийн төсөлд санал авах, SWOT шинжилгээ хийх ажил хийгдэж байна.	
4.3	Авлига, ашиг сонирголоос урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх		Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	-	100	2025 оны эхний хагас жилд ХАСУМ-ийг 7 ажилтан, ХАСХОМ-ийг 25 ажилтан тус тус хуулийн хугацаанд мэдүүлсэн. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх 12 арга хэмжээг төлөвлөн ажиллаж байна. Хэрэгжилт-91,7%. Авлигатай тэмцэх газрын урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн комиссар Н.Батчулуунтай хамтран “Авлигын шалтгаан нөхцөл, хор хөнөөл” сэдэвт танхимын сургалтыг	90

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /Хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
						2025 оны 05 дугаар сарын 27-ны өдөр зохион байгуулж, 83 ажилтныг хамруулсан. Авлигатай тэмцэх газрын 2025 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн 04/8655 тоот зөвлөмжийн хүрээнд 13 арга хэмжээг төлөвлөн биелэлтийг ханган ажиллаж, тайланг 2025 оны 6 дугаар сарын 05-ны өдрийн 297 тоот албан бичгээр хүргүүлсэн. Хэрэгжилт-93,8%.	
4.4	Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааг эрчимжүүлж, эмч, эмнэлгийн ажилтны ёс зүйг төлөвшүүлж, ажиллах		Зохион байгуулсан сургалтын тоо	9	10	Нийслэлийн Эрүүл мэндийн газрын Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хорооны 2025 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн 06 дугаар тогтоолоор 5 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр СБЭМТ-ийн Ёс зүйн хэсгийн хороог шинэчлэн байгуулсан.	30
			Хамрагдсан хүний тоо	202	210	2025 оны эхний хагас жилд 2 удаа “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй ба мэдрэмж, Цахим орчин дахь ёс зүйн асуудлууд, Харилцаа ба хандлага-Хамт олны өмнө хүлээх үүрэг” сэдвүүдээр 2 удаагийн сургалтад 70 эмч, ажилтныг хамруулсан.	

д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /Хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
						Шинэ ажилтныг чиглүүлэх сургалтыг 2 удаа зохион байгуулж, нийт 40 ажилтанг хамруулсан.	
4.5	Албан хэрэг хөтлөлтийн ERP, Edoc систем, хос бичиг ашиглалтыг сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлэх	5.0 СБЭМТ	Систем хэрэглэгчийн тоо	128	200	Сүхбаатар дүүргийн Эрүүл мэндийн төвд ERP нийслэлийн дотоод системд бүртгэлтэй 118 эмч, эмнэлгийн ажилтан байна. Үүнээс 33 ажилтан нь eDoc албан хэрэг хөтлөлтийн системд бүртгэлтэй байна. Байгууллагын эмч, ажилтнуудаас Монгол бичгийн мэдлэгийн түвшингийн судалгаа авч хэрэгцээ, шаардлагыг тодорхойлсон. Судалгаанд 81 эмч, ажилтан хамрагдсан. Үүнээс: - Сэргээх шаардлагатай- 37%, -Унших, бичих чадвартай- 44,5%. Судалгаанд оролцсон нийт ажилтнуудын 69,1% нь Монгол бичгийн хичээлд хамрагдах хүсэлтэй гэсэн үр дүн гарсан. Байгууллагын хамт олныг Монгол бичгээр албан бичиг боловсруулах, мэдлэг чадвараа дээшлүүлэх ажлыг эрчимжүүлэх чиглэлээр 2025 оны эхний хагас жилд 4 алба, тасаг нэг нэгнээ уриалах зарчмаар "Эх хэлээрээ зөв бичигцгээе"	70
			Систем ашиглах сургалтад хамрагдсан ажилтны тоо	15	200		
			Монгол бичгийн сургалтад хамрагдсан ажилтны тоо	-	100		
			Албан хэрэг хөтлөлтийн зөрчил	93	0		

д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /Хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
						уриатай Монгол бичгийн аян зохион байгуулсан. Тус аяны хүрээнд 4 удаагийн өдөрлөг зохион байгуулж, нийт ажилтнуудын 80% нь хамрагдсан. Нийт ажилтнуудад үндэсний бичгийн сургалтыг 3 дугаар улиралд зохион байгуулахаар бэлтгэн ажиллаж байна.	
4.6	Мэргэжлийн зэрэг ахиулах, шинээр хамгаалах эмч мэргэжилтнүүдэд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, дэмжлэг үзүүлэх		Зөвлөх зэрэгтэй ажилтны тоо	1	2	Эрүүл мэндийн сайдын 2019 оны “Журам шинэчлэн батлах тухай” А/513 дугаар тушаалаар батлагдсан “Мэргэшлийн зэрэг олгох, нөхөн олгох, хүчингүй болгох журам” шинэчлэгдэж, мэргэшлийн зэргийн шалгалт зохион байгуулалтын ажилд бэлтгэн 2025 онд мэргэшлийн зэрэг ахиулах болон шинээр хамгаалах эмч, сувилагч, мэргэжилтнүүдийн судалгаа нэлээдсэн. Эхний 5 сарын байдлаар мэргэшлийн зэрэгтэй 54 ажилтан ажиллаж байна. Үүнд: - Зөвлөх зэрэгтэй-1 - Тэргүүлэх зэрэгтэй-18 - Ахлах зэрэгтэй- 35 Зэрэгтэй 5 ажилтан өөр ажилд шилжин ажиллах, ажлаас чөлөөлөгдсөнтэй холбоотой зэрэгтэй ажилтны тоо буурсан.	30
			Тэргүүлэх зэрэгтэй ажилтны тоо	20	23		
			Ахлах зэрэгтэй ажилтны тоо	38	40		

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /Хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
4.7	Архив албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгт бэлтгэж, үнэлгээнд хамрагдаж, үнэлгээний мөрөөр алдаа, зөрчлийг бууруулж ажиллах		Үнэлгээний дүн	81	85	Эрүүл мэндийн төвийн даргын 2025 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн А/63 дугаар тушаалаар “Баримт нягтлан шалгах комисс”-ыг шинэчлэн байгуулсан. Сүхбаатар дүүрэг үүсэн байгуулагдсны 60 жилийн ойн хүрээнд дүүргийн "Дүүргийн түүх- Бидний түүх" сэдэвт түүхчилсэн лавлах үйлдэх аяны хүрээнд тус Эрүүл мэндийн төвөөс хийсэн ажлын тайланг 2025 оны 06 дугаар сарын 06-ны өдөр хүргүүлсэн. Улсын үзлэг Архив албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэг 2025 оны III, IV улиралд багтаан хийгдэх тов гарсан бөгөөд бэлтгэх төлөвлөгөө гарган ажиллаж байна.	30
4.8	Кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээг хийлгэн гарсан дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах		Эрсдэлийн үнэлгээний тоо	-	1	System center ХХК, MSQ institute ХХК, World standart consulting ХХК, MonCertf ХХК, Кибер шилжилт ХХК зэрэг компаниудаас үнийн санал авч, байгууллагын Өмч хамгаалах зөвлөлийн комиссын 2025 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн №10 дугаар хурлаар авч хэлэлцсэн. Хурлаар мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийлгэх	30

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /Хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
						ажлыг Сангийн сайдын 2024 оны “Журам батлах тухай” А/118 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Нээлттэй тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулах журам”-ын дагуу тендер зарлахаар шийдвэрлэж, тендерийн баримт бичгийг бүрдүүлсэн. 2025 оны 06 дугаар сард багтаан тендерийг зарлахаар төлөвлөсөн.	
4.9	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангахад санхүүгийн мэдээ, мэдээллийг цаг тухай бүрт бэлтгэн мэдээлж ажиллах		Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	98	100	2025 оны 1-р улирлын санхүүгийн мэдээ, мэдээллийг шилэн дансны тухай хуулийн дагуу тухай бүр тайлагнаж байна.	100
4.10	Байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт, шинжилгээ үнэлгээ хийж, түүний мөрөөр илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээ авч, хэрэгжилтийг хянах		Хяналт шинжилгээ үнэлгээний тоо	4	5	Байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт, шинжилгээ үнэлгээний чиглэлээр 2025 онд 6 зорилтын хүрээнд 29 ажил төлөвлөн ажилласан төлөвлөгөөний биелэлт 74,5% тай байна. - Бүрэн хэрэгжсэн -14/100%/ - Хэрэгжүүлэх шатандаа -6/30%/ - Хугацаа болоогүй - 9 Төлвөлөгөөт хяналтыг 5 удаа, төлөвлөгөөт бус хяналтыг 2 удаа	100

д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /Хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
						зохион байгуулсан. Дундаж үнэлгээ 57,2%6 Үнэлгээний дагуу нийт 35 зөвлөмж гаргаж, ажилласнаас биелэлт 73,3% тай байна. 2025 онд эхний улирлын байдлаар удирдлагын зөвлөлийн хурлыг 15 удаа зохион байгуулж 60 үүрэг даалгавар өгөгдсөн байна. Үүрэг даалгаврын биелэлтэд үнэлгээ хийхэд дундаж хувь 77 %-тай байна. Мөн Захиргаа удирдлага хүний нөөцийн алба, хуулийн зөвлөх, Авлигатай тэмцэх газрын урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэстэй хамтран эмч эмнэлгийн ажилтны хууль зрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх хүрээн “Хөдөлмөрийн тухай хууль”, “Авлигатай тэмцэх хууль”, ЭМТ-ийн даргын 2025 оны 01 дүгээр сарын 27 өдрийн А/10 дугаар тушаалаар батласан “Дотоод журам”-ыг давхардсан тоогоор 389 эмч эмнэлгийн ажилтанд сургалт зохион байгуулсан.	
Стратегийн зорилт 5. Дүрмээр хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд: Байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дэмжсэн төсөвлөлт, хөрөнгө оруулалт, санхүүжилтийн арга хэмжээг хууль, журамд нийцүүлэн хэрэгжүүлэх (АХ-2.2.4, ЗГҮАХ-2.1.7, 2.1.9, 2.1.12)							

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /Хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
5.1	Эрүүл мэндийн даатгал, төлбөртэй тусламж үйлчилгээний үр дүнг дээшлүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх		Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	100	100	Санхүүжилтийн гүйцэтгэлийн хяналт: ЭМДЕГ-тай Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2025 оны 04-р тогтоолыг үндэслэн жилийн төсөв 8,244,329,000 төгрөгийн санхүүжилтээр гэрээлсэн. Гэрээний тоо хэмжээний дагуу 3–9-р сард хувиарлалт хийж гүйцэтгэлийг хянан, тоо хэмжээний хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Хэрэгжүүлсэн арга хэмжээнүүд: Амбулаторийн тусламж үйлчилгээ, Хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээ, яаралтай тусламж үйлчилгээний хүрээнд эмч нарын үзлэгт HICs болон eHealth програмаас өдөр бүр, 7 хоног бүр, сар болгон хяналт тавьж арга зүйгээр хангаж ажиллаж байна. Эрт илрүүлэг: -2025 оны 1, 2, 3 -р сарын Эрт илрүүлгийн гүйцэтгэлд хяналт хийж нэгтгэсэн. Дүгнэлийн хүрээнд 944 иргэн эрт илрүүлэгт хамрагдсан ба нийт нэхэмжилсэн мөнгөн дүн 168,890,000₮, олгогдохоор тооцоолсон	70

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /Хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
						163,037,000₮, хасагдал 5,853,000₮ байна. Хасагдлын шалтгаанд дүгнэлт хийж, сайжруулах зөвлөмжийг гаргаж, эмч, сувилагч нарт сургалт, зөвлөмж өгч ажиллаж байна. Төлбөртэй тусламж үйлчилгээний төлөвлөлт: ЭМТ-ийн даргын 2024 оны 04 сарын А/28 дугаар тушаалаар төлбөртэй тусламж, үйлчилгээг 14 бүлгийн 168 төрлийн үйлчилгээг иргэн, аж ахуй нэгж байгууллагын хүсэлтээр үзүүлж байна. Эрүүл мэндийн даатгалын тусламж үйлчилгээний хамтын төлбөрийн зохицуулалттай оношийн хамааралтай бүлгээр судалгаа гаргаж, улаан хоолой ходоодны дуран, бүдүүн гэдэсний дуран, дурангаар хийх ажилбар, зүрхний холтер, нүдний ОСТ зэрэг тусламж үйлчилгээний тоо хэмжээг нэмэгдүүлэхээр 5 төрлийн видео контент хийж олон нийтийг мэдээллээр хангасан. Үр дүн : Хамтын төлбөртэй тусламж үйлчилгээ 2024 оны эхний хагас жилийн гүйцэтгэлтэй харьцуулахад 18,3% иар өссөн байна.	

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /Хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
						Цаашид энэ нь 30-50% иар өсгөх төлөвлөлт хийн ажиллаж байна. Эрүүл мэндийн даатгалд нэхэмжлэх үр ашгийг нэмэгдүүлэх, тусламж үйлчилгээг хүртээмжтэй байлгаж төвлөрлийг сааруулах зорилгоор дараах шинэ үйлчилгээг нэвтрүүлэхээр төлөвлөсөн. Үүнд: -Компьютерт томографийн (КТГ) оношилгоо - Нүдний ОСТ (оптик когерент томограф) - Хавдрын үеийн хөнгөвчлөх тусламж үйлчилгээ - Сэргээн засах хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээ гэх мэт	
5.2	ТБОНӨХБАҮХА тухай хуулийн дагуу Худалдан авах үйл ажиллагааг Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль болон холбогдох журамд нийцүүлэн ил тод шуурхай, зохион		Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	83	90	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу 6 тендер зарлах төлөвлөгөөтэйгөөс нийт 5 тендер амжилттай зарлаж сонгон шалгаруулалтыг хийгээд байна. Сэргээн засах төвийн барилгын гадна фасад засварын ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерт Хан хүннүй ХХК, Эрүүл мэндийн төв, Нэгдсэн эмнэлгийн	70

д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /Хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
	байгуулж хугацаанд нь чанартай гүйцэтгэх					харуул хамгаалалтын ажил гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерт Бумбат зүрх ХХК, Салбар амбулатори 1-ийн барилгын дуусгал ажлын тендерт Эм Жи Си ХХК нар шалгарч тендерийн гүйцэтгэлийг гэрээнд заасан үүргийн дагуу ханган ажиллаж байна. Эм тариа эмнэлгийн хэрэгсэл, Лабораторын урвалж уусмалыг нийлүүлэх нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендерийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахаар тендерт ирүүлсэн материалд хяналт хийж байна. Нийт эм, эмнэлгийн хэрэгслийн 26 багц тендер зарласанаас 17 багцад оролцогч байгууллагууд саналаа хүргүүлсэн.	
5.3	Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого 2025-2028 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 6.4.6 дахь заалт "Төрийн худалдан авалтыг ногоон худалдан авалтад үе шаттайгаар шилжүүлэх, хувийн		Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	-	-	Ногоон худалдан авах үйл ажиллагаа зохион байгуулагдаагүй байна.	0

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /Хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
	хэвшлийг дэмжих тогтолцоог бүрдүүлэх”, ногоон худалдан авах ажиллагааг зохион байгуулах						
5.4	Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн “Дотоодын үйлдвэрээс бараа, материал худалдан авах” 90 дүгээр тогтоолын дагуу чанар стандартын шаардлага хангасан бараа бүтээгдэхүүнийг дотоодын үйлдвэрлэгчээс худалдан авах ажиллагааг хэрэгжүүлэх		Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	-	2	2025 оны 06 дугаар сарын байдлаар нийт 951 сая төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл болон эмнэлгийн тусламж үйлчилгээнд шаардагдах хангамжийн материал худалдан авсанаас дотоодын үйлвэрлэлийн аж ахуй нэгж байгууллагаас 48,791 мянган төгрөгийн худалдан авалтыг хийсэн байна. Энэ нь нийт худалдан авалтын 5.1% байна.	30
5.5	Төсвийн орлогын төлөвлөгөөг оновчтой төлөвлөн, хэрэгжилтийг хангаж ажиллах	15,329.9	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	100	100	2025 оны 05 дугаар сарын байдлаар Төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогоор санхүүжих төлөвлөгөө 195,881,500 төгрөг үүнээс төвлөрүүлсэн дүн 233,262,935 төгрөг гүйцэтгэл 119% Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих төлөвлөгөө 6,654,091,300 төгрөг	90

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /Хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
						үүнээс санхүүжсэн дүн 6,475,388,686.19 төгрөг гүйцэтгэл 97 % байна. 2025 оны 04 дүгээр сарын байдлаар ЭМДЕГазраас авах авлага 660,244,817 төгрөг байна.	
5.6	Батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр дүнтэй зарцуулж, өр авлага үүсгэхгүй байх, төсвийн гүйцэтгэлийг хуулийн хугацаанд тайлагнаж ажиллах	15,329.9	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	98	100	Төсвийн гүйцэтгэлийн тайлан сар бүрийн 2-ны өдрийн дотор харьяалагдах газарт хүргүүлж ажилласан. Жилийн хэмжээнд нийт 12 удаагийн мэдээг 2 газарт нийт 24 тайланг хүргүүлэх ёстойгоос 1-5 дугаар сарын гүйцэтгэл болох 10 тайланг цаг хугацаанд нь хүргүүлж ажилласан байна. 2025 оны 05 сарын 30-ны өдрийн байдлаар эм, эмнэлгийн хэрэгслийн өр 95,305,550 төгрөг байгаа ба холбогдох бичиг баримтын бүрдэл дутуу, 06 дугаар сард бүрэн барагдуулна.	90
5.7	2026 оны төсвийн төсөл, 2027-2028 оны төсвийн төсөөллийг хуулийн хугацаанд нь боловсруулж, холбогдох байгууллагад хүргүүлж, ажиллах		Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	100	-	Төсвийн төсөөлөл боловсруулж байна. 2025 оны 06 дугаар сарын 13-ны дотор хүргүүлнэ.	30

д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /Хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
5.8	2026 оны тогтмол зардлын төсвийн төсөл, 2027-2028 оны төсвийн төсөөллийг хуулийн хугацаанд боловсруулж, холбогдох байгууллагад хүргүүлэх		Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	100	100	Төсвийн төсөөлөл боловсруулж байна. 2025 оны 06 дугаар сарын 13-ны дотор хүргүүлнэ.	30
5.9	Төрийн албаны тухай хуулийн 60 дугаар зүйл 60.1 дэх заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 29 дүгээр зүйл 29.2 дахь заалтын дагуу өндөр насны тэтгэвэрт гарч байгаа албан хаагчдын болон ЭМТ тухай хуулийн 29 дүгээр зүйл 29.5 дахь заалтын дагуу өрх тосгоны эрүүл мэндийн төвд тогтвор суурьшилтай ажилласан эмнэлгийн мэргэжилтэнд олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийн материалыг бүрдүүлэн тооцооллыг хийж, олгох		29.2 дахь заалтын дагуу тэтгэмж олгох ажилтны тоо	6	14	Тус ЭМТ- өөс 2025 онд өндөр насны тэтгэвэрт гарах 14 албан хаагч байгаагаас 2025 оны 02 дугаар улиралд нийт 8 ажилтан өргөдөл өгч, 29,2 дахь заалтын дагуу тэтгэмж олгохоор бичиг баримтын бүрдүүлэлт бүрэн хангасан 5 ажилтны мэдээллийг НЭМГазарт хүргүүлсэн байна. Тэтгэмжийн санхүүжилт олгогдоогүй.	100
			29.5 дахь заалтын дагуу тэтгэмж олгох ЭМТ-ийн ажилтны тоо	43	73	СБД-ийн ЭМТ-ийн 11 ажилтанд 29.5 дахь заалтын дагуу тэтгэмж олгогдсон.	100

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /Хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
5.10	Санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланг хуулийн хугацаанд нь хүргүүлэх		Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	100	100	2024 оны санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланг хуулийн хугацаанд хүргүүлэн ажилласан. 2024 оны гүйцэтгэлийн аудитын шалгалтаар “Өөрчлөлтгүй” дүгнэлт авсан бөгөөд зөвлөмжийн дагуу үйл ажиллагаагаа эрчимжүүлэн ажиллаж байна. 2025 оны эхний хагас жилийн тайлангийн бэлтгэл ажлыг бүрэн хангасан.	100
5.11	2024 оны жилийн эцсийн санхүүгийн аудитын шалгалтаар илэрсэн зөрчил, зөвлөмж, албан шаардлагыг хэрэгжүүлэх төлөвлөгөөг гарган хэрэгжилтийг хангаж ажиллах		Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	100	100	Эвиденсе ХХК байгууллагын 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийж, “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн бөгөөд НББүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн боловсруулах 1 зөвлөмжийг ирүүлсэн. Зөвлөмжийн дагуу НББүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулах мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллахаар судалж үнийн саналыг авсан байна.	90

д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /Хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
5.12	Монгол Улсын Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/250 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын дагуу Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (tender.gov.mn)-ээр худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг санхүүжилтийн эх үүсвэр батлагдснаас хойш ажлын 10 хоногт багтаан батлуулах, тайланг төсвийн жил дууссан даруйд системээр тайлагнаж ажиллах		Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	100	100	Төрийн өмчийн хөрөнгөөр 2025 оны бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдаж байгаа тендерүүдийн мэдээллийн “Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем”-д тухай бүр тайлагнаж ажиллаж байна. 2025 онд нийт 6 тендер зарлах төлөвлөгөөтэй үүнээс одоогийн байдлаар 4 тендерийг амжилттай зарлаж 3 тендерт гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан. эм эмнэлгийн хэрэгсэл лабораторийн урвалж уусмалыг нийлүүлэх нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендерийг 26 багц болгон зарласан ба 17 багцад оролцогч байгууллагууд саналаа ирүүлсэн. Хуулийн хугацаанд ирүүлсэн материалыг хянан үзэж шалгаруулалт хийхээр ажиллаж байна. Сонгон шалгаруулалтын дараа амжилтгүй болсон багцыг ахин багцлалтын байдлыг хянан үзэж нээлттэй тендер зарлах болно.	30
5.13	Шинээр нэмэгдүүлж буй тусламж үйлчилгээний		ЭМДЕГ-тай гэрээлсэн	1	2	Шинээр нэмэгдэж буй тусламж үйлчилгээний ертгийн тооцооллыг	100

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /Хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
	өртгийг үндэслэлтэй тооцоолж, үйл ажиллагаанд нэвтрүүлэх		шинээр гэрээлсэн тусламж үйлчилгээний чиглэлийн тоо			хийж байна. Одоогийн байдлаар нийт 5 тусламж үйлчилгээний өртгийн тооцооллыг гүйцэтгэсэн.	
5.14	Төсвийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын хэрэгжилтийг ханган ажиллах		Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	100	100	Төсвийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Мөн гүйцэтгэлийн аудитын зөвлөмжийн дагуу НББүртгэлийн бодлогын баримт бичгийг гүйцэтгэх компанитай гэрээ байгуулан ажиллаж байна.	100
5.15	Монгол Улсын “Төсвийн тухай”, “Нягтлан бодох бүртгэлийн тухай”, “Татварын хууль”, “Нийгмийн даатгалын тухай” хууль, “Төрийн хэмнэлтийн тухай” хууль, НББОУС болон бусад холбогдох хууль, тогтоол, тушаал, зааврыг мөрдлөг болгон санхүү бүртгэлийн ажилтанг удирдлагаар ханган,		Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	100	100	НББүртгэлийн хөтлөн явуулахад холбогдох хууль тогтоомжийг хэрэгжилтийг ханган ажиллаж өнөөдрийн байдлаар цалин хөлс нэмэгдэл урамшууллын зарлаас нийт 545 сая төгрөг батлагдсан төсвийн 26,73%-ийг, хангамж бараа материалын зардлаас 40 сая төгрөг батлагдсан төсвийн 49,14%-ийг, эм бэлдмэл эмнэлгийн хэрэгслийн зардлаас 530 сая төгрөг батлагдсан төсвөөс 36%-ийг тус тус хэмнэсэн байна.	100

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /Хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
	бүртгэлийн ажлыг зохион байгуулж санхүүгийн үйл ажиллагаа, үр дүнг тооцон ажиллах					Нийт үйл ажиллагааны зардлаас 18,31% ийн хэмнэлтийг хийсэн байна.	
5.16	Байгууллагын эд хөрөнгийн тооллогыг хагас, бүтэн жилээр хийж, төрийн өмчийн ашиглалт, хамгаалалтад хяналт тавих, тайлагнаж, үр дүнг дээшлүүлж ажиллах	-	Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар	100	100	Сүхбаатар дүүргийн Эрүүл мэндийн төвийн даргын 2024 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн А/137 дугаар тушаалаар батлагдсан ажлын хэсгийн бүрэлдэхүүн батлагдсан хуваарийн дагуу 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан тэнцлийн дүнд тулгуурлан эд хөрөнгийн үзлэг тооллогыг хийж, нийт 29,184,361,993.90 төгрөгийн үндсэн хөрөнгө, бараа материалыг тоолж, санхүүгийн программ болон эд хариуцагчийн бүртгэлд тусган шинэчилсэн. Тооллогын бүрэлдэхүүн тооллогын дүгнэлт болон тооллогын явцад байгууллагын өмчийг эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хадгалалт хамгаалалтыг сайжруулах, үр ашгийг дээшлүүлэх чиглэлээр 12 төрлийн зөвлөмжийг гаргаж, зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулахаар ажиллаж байна.	70

Д/Д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /Хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
Стратегийн зорилт 6. Дүрмээр хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд: Эмнэлгийн дэд бүтэц, автомашин, тоног төхөөрөмж, цахим үйлчилгээг өргөжүүлэн үйл ажиллагааг бэхжүүлэх (МУЗГҮАХ-2.3.3.1, 2.1.4.1, 2.1.6, 4.2.1.12, НХТЖТ-2.11.1)							
6.1	Цахим эрүүл мэндийн дэвшилтэт технологи, телемедицин, хиймэл оюун ухаанд суурилсан тоног төхөөрөмж, үйлчилгээг эмчилгээ, оношилгоо, хяналтад нэвтрүүлнэ.		Зүрхний эхо болон Компьютер томографи	1	3	СБЭМТ-ийн Сэлбэ эмнэлэгт орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар нийлүүлэгдсэн 2 аппаратыг угсарч, суурилуулан дүрс архивлах системд холбох бэлтгэл ажлуудаг тус тус гүйцэтгэж байна. Үүнд: Сетунари ХХК-ны нийлүүлсэн компьютер томограф siemens GO загварын 128 зүслэгтэй аппарат, биосистемс ХХК-ны нийлүүлсэн GE загварын зүрхний эхо аппарат	90
6.2	Сүхбаатар дүүргийн 11-р хорооны нутаг дэвсгэрт байрлах Эрүүл мэндийн төвийн барилгын халаалт, агаар сэлгэлтийн шугам сүлжээний их засварын ажлыг хийх	1,015.02 СБДЗДТ Г	Барилгын засварын ажлын гүйцэтгэлийн хувь	100	100	СБД-ийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны 12 сарын 02/16 дугаар тогтоолоор батлагдсан Сүхбаатар дүүргийн 2025 оны төсөвт Эрүүл мэндийн төвийн барилгын халаалт, агаар сэлгэлтийн шугам сүлжээний их засварын ажлыг санхүүжүүлэхээр 1,015,027.3 төгрөгийн төсөв батлагдсан. СБДЗДТГ аас ажил гүйцэтгэгчийг шалгаруулах тендерийг 2025 оны 03 дугаар сард зарлаж. 06 дугаар сарын	30

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /Хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтг элийн хувь
						15 өдөр хүлээлгэж өгөхөөр гэрээ байгуулсан.	
6.3	Сүхбаатар дүүргийн 3-р хорооны нутаг дэвсгэрт байрлах Салбар амбулаторийн барилгын ажлыг дуусгаж, ашиглалтад оруулах	420.4 СБЭМТ	Барилгын засварын ажлын гүйцэтгэлийн хувь	85	100	СБДЭМТ/202501020003 “Салбар амбулатори 1-ийн барилгын дуусгал ажлын тендер”-ийн сонгон шалгаруулалтыг 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдөр зарласан 06 дугаар сарын 15-нд ашиглалтад хүлээлгэн өгөхөөр гэрээ байгуулсан.	70
6.4	Сүхбаатар дүүргийн 13-р хорооны нутаг дэвсгэрт шинээр нээгдсэн “Сэлбэ” эмнэлэгт эрчимт эмчилгээнд шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах	300.0 НТ	Тоног төхөөрөмжийн тоо	-	33	“Сэлбэ” эмнэлэгт эрчимт эмчилгээнд шаардлагатай 300,000,000 төгрөгийн тоног төхөөрөмжийн судалгааг гарган техникийн үзүүлэлтийн хамт НЭМГ-т хүргүүлж, Нийслэлийн 2025 оны төсвөөс санхүүжүүлэхээр батлагдсан. Үүнд: өвчтөний хяналтын нэгдсэн систем-2, өвчтөний хяналтын монитор-10, тариурын автомат шахуурга-10, дуслын автомат шахуурга-10, амьсгалын аппарат-2.	30
6.5	Шинээр нийлүүлэгдсэн болон нөөцөд бүртгэлтэй эмнэлгийн тоног төхөөрөмжийг үйл ажиллагаанд нэвтрүүлж, ашиглалт, үр дүнг ахиулах	2,700.0 СБДЗДТ Г	Үйл ажиллагаанд шинээр нэвтрүүлсэн тоног төхөөрөмжийн тоо	3	6	СБД-ийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны 12 сарын Сүхбаатар дүүргийн 2025 оны хөгжлийн төлөвлөгөө батлах тухай 02/13, Дүүргийн 2025 оны төсөв батлах тухай 02/16 дугаар тогтоолоор ЭМТ, Сэлбэ эмнэлэг, Сэргээн засах төвд	30

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /Хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
						шаардлагатай эмнэлгийн тоног төхөөрөмж, материаллаг баазыг бэхжүүлэхэд 2,7 тэрбум төгрөгийн санхүүжилт батлагдсан. Үүний хүрээнд шаардлагатай эмнэлгийн тоног төхөөрөмжийн техник үзүүлэлтийг боловсруулан СБДЗДТГ-т хүргүүлж, төсвийг шийдвэрлүүлсэн. Сүхбаатар дүүргийн Засаг даргын тамгын газраас СБДХААА/20250102010 дугаартай “Дүүргийн Эрүүл мэндийн төв болон түүний харьяа дүүргийн эмнэлгүүдийн тоног төхөөрөмж, материаллаг бааз бэхжүүлэх” тендер шалгаруулалтын үр дүн гарч, гэрээ хийх шатанд байна.	
Нийт 74 арга хэмжээ, хэрэгжилт 70,5%							

ХЯНАСАН:
 ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
 ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
 НЭГТГЭСЭН:
 ТӨЛӨВЛӨЛТ, ГАДААД ХАРИЛЦАА
 ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН



 Б.БАЯРМАА

 Б.ЛХАГВАЖАВ